



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/747

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Сүү цагаан идээ борлуулах цэг байгуулах" ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Цогтсайхан - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын Газрын газрын удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн

Д.Манат - Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн

Б.Түмэнжаргал - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

С.Батдорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга

Г.Нансалмаа - Баатархайрхан багийн Засаг дарга

Д.Байгальмаа - Буянт багийн Засаг дарга

Нарийн бичгийн

дарга: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

02.3735
Zah A/747 Kh

2. “Сүү цагаан идээ борлуулах цэг байгуулах” ажлыг хүлээн авахтай холбогдон гарах зардлыг тухайн төслийн техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Тухайн ажлыг төсвийн дагуу шалгаж, норм нормативыг баримт бичигт заасан техникийн үзүүлэлт, шаардлагын дагуу гүйцэтгэсэн эсэхийг хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн дарга /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН